

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-18
1. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	4-18

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 04-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 26 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга;

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Л.Мөнхбаатар, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: У.Отгонбаяр.

Нэг.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Улсын Их Хурлын даргын зөвлөх Н.Отгончимэг, Т.Алтангэрэл, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, мөн яамны захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтсийн дарга Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Б.Өлзийсайхан, “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Т.Хурцбилэг байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 12
Бүгд: 17
29.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3.3 дахь заалтын “ , жөндөрийн мэдрэмжтэй” гэснийг болон 17.3.2 дахь заалтыг тус тус хасаж, 17.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.3.4.хязгаарлалт нь зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Алтанхуяг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 11
Бүгд: 17
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Д.Цогтбаатар: 3.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3 дахь хэсгийн 17.3.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 10
Бүгд: 17
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ажлын хэсэг дахин ажиллах шаардлагатай байгаа тул уг асуудлын анхны хэлэлцүүлгийг 7 хоног хойшлуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул уг асуудлын анхны хэлэлцүүлгийг хойшлуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 00 минут үргэлжилж, 22 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 77.3 хувийн ирцтэйгээр 11 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН

ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим, 10 цаг 26 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Хууль зүйн байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Дашдондогийн Ганбат, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүд ирснээр ирц бүрдсэн байна. Ирц 63,6 хувьтай. Ингээд Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх 1 асуудал байгаа. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ байгаа.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрсээ өгнө үү. Байхгүй байна. Ингээд хэлэлцэх асуудлаа баталлаа.

Хэлэлцэх асуудалдаа орёе. **Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг танилцуулна. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүнээс 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанаар төслийг үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэхийг дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 3 дугаар тогтоолоор Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгээр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, С.Эрдэнэболд нарын гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Түүнчлэн 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийг төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх бүрэлдэхүүнийг Хүний эрхийн Үндэсний Комисс, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатын шүүх, Ерөнхийлөгчийн тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн үндэсний хүрээлэн болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, албан хаагчдыг оролцуулан баталсан болно.

Энэ хугацаанд ажлын хэсэг 3 удаа, ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх бүрэлдэхүүн тус бүр 3 удаа хуралдсан бөгөөд хуулийн төслийн талаар 12, найруулгын 3 санал, хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар 5 санал боловсруулсныг та бүхэнд танилцуулж байна. Үүнд:

1.Хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд хязгаарлалт нь зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх шаардлагыг хангасан эсэхийг хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээнд нэмж тусгахаар;

2.Тухайн жилийн улсын төсөв, төсвийн тодотголын хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгахаар;

3.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн судлаач хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээр;

4.Төсөлд тусгагдсан хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг баталснаар үүсэх зардлын тооцоог үнэлж, тодорхойлох шаардлагаас эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлэх асуудлыг хасахаар;

5.Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад тусгахад тавигдах шаардлага гэсэн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.2} дахь хэсгийг өөрчлөн найруулахаар;

6.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг 2025 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр;

7.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолоор хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хууль санаачлагчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн холбогдох байгууллагуудын албан хаагчдыг холбогдох аргачлал, арга зүйгээр хангах, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж хэрэгжүүлэх. Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд эрх олгогдоогүй бөгөөд дээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох, Хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын удирдлагад даалгахаар;

8.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх зэрэг болно. Дээрх саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүнд баярлалаа. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсэгт Отгончимэг Улсын Их Хурлын даргын зөвлөх, Дондогмаа Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга, Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Агар-Эрдэнэ Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх, Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтсийн дарга, Өлзийсайхан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Эрдэнэчимэг “Нээлттэй нийгэм форум” Төрийн бус байгууллагын Засаглалын хөтөлбөрийн менежер гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Ажлын хэсэг ямар ч байсан ажиллаад ороод ирсэн юм байна. Би бас цөөн хэдэн саналууд бас гаргасан. Тэгэхдээ 1 л зүйлийг би зүгээр тодруулж хэлмээр байна. Уг нь бол хууль тогтоомжийн төслийг боловсруулахдаа дагалдан гарах хуулийн төслүүд болон дагалдан гарах хэм хэмжээ тогтоосон актуудыг

хамтад нь боловсруулаад, хууль тогтоогчид танилцуулах энэ заалтыг л барьчихад өнөөдрийн яриад байгаа бүх зүйлүүд шийдэгдэх байхгүй юу.

Дагаад энэ хуулиар ийм эрх олгосон заалтын дагуу ийм ийм дүрэм журмуудыг Засгийн газар, сайд нар батлах гэж байгаа юм гэдгийг яг хамтад нь боловсруулаад, энийг нь хууль тогтоогч үзээд, энэ харилцаа бол хуульдаа суух энэ бол эрх олгох шаардлага алга гээд шийдээд явчих юман дээр өнөөдөр ийм амьдралын практикийг ерөнхийдөө харж дүгнэхгүйгээр шууд ороод ирж байгаад бас гайхаж байгаа юм.

Би тэгээд ажлын хэсгээс бас хариулах юм болов уу гэж зүгээр бодож байна. Би 2 зүйл л асууя. Захиргааны хэм хэмжээний акт батлах энэ асуудал дээр зөвхөн шаардлага тавьж байгаа юм. Гэтэл бүх эрх олгосон актууд чинь захиргааны хэмжээний акт болдоггүй. Захиргааны хэмжээний акт гэж байгаа маань Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэж байгаа актуудыг л хэлж байгаа. Эрх олгосон заалтын дагуу бусад хэм хэмжээ тогтоож байгаа актуудад ямар нэгэн шаардлага тавихгүй болж таарах гээд байгаа байхгүй. Тэгэхээр энэ зүйлүүдийг ингэж хагас дутуу, 2-ын хооронд хийж болохгүй.

2 дугаарт энэ статистик мэдээллээ буруу авчихсан байна лээ. Засгийн газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталж байгаа энэ дүрэм журмуудыг одоо болтол Хууль зүй, дотоод хэргийн яам бүртгэдэггүй байхгүй юу. Тэгээд энэ бүртгэдэггүй журмуудыг аваачаад хяналт бүртгэлгүй журам байна гээд олон нийтэд сэвсээр байгаад журмын эх орон болчихлоо гэдэг ийм зүйлийг ярьчихаж байгаа юм. Эрх олгосон заалтын хэм хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн яам тоолж байсан юм. Монгол Улсын хэмжээнд энэ бүх хуулиуд дээр 2500 орчим эрх олгосон заалт байдаг юм. Үүнээсээ үндсэндээ 500, 600 нь Загийн газар, Ерөнхийлөгч баталж байгаа байхгүй юу. Ийм зүйлүүдийг олон нийтэд буруу зөрүү өгч байгаад ингээд асуудлыг ийм хөнгөн хуумгай хандаж байгаад би харамсаж байгаа юм.

Тэгээд яг эцсийн дүндээ энэ хэм хэмжээ тогтоосон актуудын хяналт бүртгэлийг Хууль зүй, дотоод хэргийн яам хийх юм уу, эсвэл цаашдаа бас Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн явж байгаа дээр хууль тогтоомжийн агентлаг гэж байгуулаад, Ерөнхий сайдын дэргэдээ хянадаг. Эсвэл дараагийн хувилбар бол парламентын дэргэд авчирч хянадаг ийм зүйл байж болдог. Энийг ингээд бусад орнууд хийгээд явдаг. Энэ рүүгээ их тогтолцооны өөрчлөлтөө хийчихмээр байгаа юм. Тэгээд ийм зүйлүүд байж байж энэ хууль тогтоомжийг боловсруулах хэсэг дээр ингэж хагас дутуу орж ирж байгаа.

Одоо хамгийн эмгэнэлтэй юмнууд нь ийм байгаа. Монгол Улсын Үндсэн хуульд гагцхүү хуулиар тогтоохоор заасан харилцаа гэж байгаа юм. Үүний чинь цаана Сонгуулийн хуулийг дагаад баахан дүрэм журам гарчихсан байгаа. Энэ сонгуулийн хууль тогтоомжийг дүрэм журам гаргуулахгүй гэсэн үг үү. Энэ дээр нэг хариулаач.

Одоо 1 дүгээр санал хураалт байгаа. Хязгаарлалт нь зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, боломжит хамгийн гээд энийг хэн үнэлэх юм. Ингээд хууль санаачлагч бүрэн эрхийн асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газрын захиргааны ажилтнуудын гарт өгөөд, энэ ингээд өргөн барих гэж байгаа хүмүүсийн бөөн эрүүл болно..../минут дуусав/

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Яах вэ энэ хуулийн үзэл санаа бол та ч бас мэдэж байгаа. Бид нар хуулийн бус журам дүрмийн улс болчихоод байгаа. Тэгээд энэ бас бодит байдал үүгээрээ бид нар яг хууль зүйн нөгөө системийн хувьд хууль засаглах ёстой байтал хуулиас давсан дүрэм журмууд гарч, хүний эрхийг хөнддөг эсвэл төрийн ажиллагаа гацдаг, цаашлаад хэлэх юм бол авлига, хээл хахуулийн орчин бүрдэх нөхцөл рүү түлхэж байна гэдэг судалгааг бас Хууль зүй, дотоод хэргийн яаманд Энхбаяр гишүүн сайд байхдаа бүр захиалж нэлээн олон дээд шүүхийн шүүгч, судлаач нараар хийлгэсэн юм байна лээ. Тэгээд яах вэ, Хууль тогтоомжийн хууль дээр нь Захиргааны ерөнхий хууль дээр бас уг нь шаардлагууд байгаа. Энэ хэрэгжихгүй байгаа. Хэрэгжихгүй байгаагийн мэдээж учир шалтгаан бол бас байгаа. Энэ дээр хяналт яагаад хийгдэхгүй байна. Энийг ер нь системийн хувьд харж байх ёстой хүмүүс нь ажиллаж байна уу, үгүй юу гэдэг юм бас байгаа. Үүнээс гадна ер нь бид нар Захиргааны ерөнхий хууль дээр зөвхөн захиргааны хэм хэмжээний акт гаргахад тавигддаг шаардлага байгаа болохоос үүнийг Улсын Их хурал хууль тогтоомжоороо өөрийнхөө хууль тогтоох эрхээ гүйцэтгэх засаглал руу шилжүүлэхдээ тэгвэл ямар хүрээ хязгаар дээр байх вэ гэдэг юм бол одоогийн Захиргааны ерөнхий хууль дээр байхгүй байгаа. Энийг л гол нь энэ хууль тогтоомжийн хууль дээр оруулж бид нар парламент Улсын Их Хурал, хууль тогтоогч өөрийнхөө бүрэн эрхийг хууль тогтоох хэмжээ гаргах бүрэн эрхээ шилжүүлэхдээ ямар хүрээ хязгаарт байх вэ. Үүнийх нь дагуу хэм хэмжээний акт нь яаж гарах нь бол мэдээж Захиргааны ерөнхий хуулиар байгаа юм.

Эхний санал дээр та асуулт асуух шиг боллоо. Энэ 17.3.4. Энэ бол Хүний эрхийн комиссоос ирсэн санал. Ер нь олон улсад ч гэсэн хүний эрхийг хязгаарлах гэж байгаа бол ерөөсөө нөгөө зорилгодоо нийцсэн байх, дээр нь Proportionality буюу авч байгаа арга хэмжээ нь бол тохирсон байх, ялгаварлан гадуурхаагүй байх гээд энэ үндсэн зарчмууд байдаг. Тэгээд энийг л илүү тодорхойлж өгсөн.

Харин энэ 13.17.3.2 дээр байсан нийтийн эрх ашгийн сонирхлын төлөө байх гэсэн энэ бол бас тодорхойлогдох боломжгүй. Дараа нь бас буруугаар ойлгогдох болох вий гэдэг утгаараа анхны хуулийн төсөл дээр байсан энэ заалтыг бол хасаж орж ирсэн юм. Ер нь бол яг таны хэлж байгаа зөв л дөө. Захиргааны хэм хэмжээний актыг бид нар тэгвэл хаана яаж бүртгээд байна гээд. Тэгээд бид нар ажлын хэсгийн хүрээнд ч гэсэн нэлээн судалсан, эрдэмтэн докторуудтай уулзсан. Улсын Их Хурлаас бас Байнгын хороодоор ингээд нийтэд чиглэсэн анкетын загвар батлах ч юм уу иймэрхүү хэм хэмжээний акт бол Байнгын хорооноос баталсан юмнууд гарсан байна лээ. Тэгээд энийг бол Улсын Их Хурлын тухай хууль 2023 оны 5 сард батлахдаа Байнгын хороогоор ийм хэмжээний актыг ер нь журам батлахгүй гэдгийг хуульдаа заагаад өгчихсөн юм байна лээ. Одоо гол нь Улсын Их Хурал өөрөө энийгээ хэрэгжүүлээд, Байнгын хороод өөр өөрсөд дээрээ гаргасан янз бүрийн дүрэм журам, акт, маягт байх юм бол тэрийгээ цэгцлэх ажил бол бидэнд байгаа. Энэ хуулиар бол мэдээж энэ бүртгэгддэг захиргааны хэм хэмжээнээс гадна Ерөнхийлөгчийн Тамгын газар гаргадаг энэ хэмжээний актад ч гэсэн бид нар зөвлөмж хүргүүлэх ёстой. Хүргүүлж байгаа тогтоолоор. Дагаж орж ирж байгаа тогтоолыг та харвал.

Дараа нь энэ шүүх, прокурортой холбоотой асуудал байгаа. Шүүх прокурортой холбоотой шүүн таслах үйл ажиллагаа өөрсдийнх нь үйл

ажиллагаатай холбоотой дүрэм, журам болон захиргааны хэм хэмжээний акт байдаггүй. Гэхдээ яах вэ нөгөө талаараа бас ийм ганц 2 кэйс үүсээд байгаа юм байна лээ. Гадаад тийшийгээ чиглэсэн. Прокурорыг сонгон шалгаруулалт хийхэд тавигдаж байгаа шаардлага энэ захиргааны хэм хэмжээний акт уу, үгүй юү гэдэг асуудал байгаа. Тэгэхээр энэ бол өөрөө нөгөө хяналт тэмцлийн асуудал байдаг учраас Хууль зүйн яаман дээрээ гэхээсээ илүү өөр системийг бид нар бас бодож олох л ёстой юм байна лээ.

Үгүй ээ үгүй, бүртгэгдээгүй ийм захиргааны хэм хэмжээний асуудал гарч байгаа кэйс бас шүүх дээр очсон байна лээ. Энд бас байгаа. Тэгэхээр энийг бид нар харин яаж хянадаг болох вэ, хяналтын систем нь хаанаа байх вэ гэдгийг бодмоор л юм байна лээ. Тэгээд шүүх өөрөө бас энэ асуудлаа зарим гарч байгаа хэм хэмжээ дээрээ хяналтаа хийдэг ч .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Эхлээд эхний асуултын чинь хариултыг гүйцээгээд өгчих Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Бүх юмыг гүйцэтгэх засаглал дээрээ бүртгэнэ гэдэг бол угаасаа дараа нь хяналт, тэнцлийн асуудал гарах учраас цааш цаашдаа бид нар бодохоор юм байна лээ. Гэхдээ энэ асуудлыг Захиргааны ерөнхий хууль дээр ч юм уу хөндөж орж ирээд, ер нь захиргааны хэм хэмжээний акт гэж юу юм, яаж бүртгэх юм гэдэг энэ асуудал энэ хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хөндөгдөж орж ирээгүй учраас ажлын хэсгийн хүрээнд бол өөрсдийнхөө ажлыг бол яг үзэл баримтлалын хүрээнд хөндөгдөж орж ирсэн зүйл заалтын хүрээнд судлаад нэмэлт, өөрчлөлт саналуудыг оруулж ирж байгаа гэдгийг хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Ийм байгаа юм. Монгол Улсад хууль тогтоогчоос олгож байгаа хэм хэмжээний эрх зүйн дэд актууд 5 янз байгаа. Байнгын хороо баталж байгаа энэ актууд байгаа. Сая намрын чуулганаар хүртэл эрүүл мэндийн ямар юмны зөвлөлийн дүрмийг батлаад л явж байна лээ. Энэ хууль хэрэгжихгүй байгаа. Улсын Их Хурлын Тамгын газар өөрөө энийгээ хэрэгжүүлэхгүй байгаа байхгүй юу.

2 дугаарт энэ шүүн таслах ажиллагаа болон хэрэг хянан шалгах ажиллагаатай холбоотой энэ дүрэм журмууд угаасаа Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэл байдаггүй учраас хууль зүй, дотоод хэргийн яам бүртгэдэггүй юм Номио. Энэ прокурор дээр бүртгэгддэг юм.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн прокурор дээр байгаа мэдээллийн сан прокурорын хяналтад байдаг чиг үүргийн хувьд. Хуулиа хар.

2 дугаарт Ерөнхийлөгч болон Засгийн газрын хэм хэмжээ тогтоосон актууд Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлнэ л гэсэн ийм заалттай. Тэгэхээр бид хэд энэ тогтолцооны хувьд юмаа авч үзэхийнхээ оронд энэ дээр 2-ын хооронд ийм зүйл орж байгаа нь бол буруу байгаад байгаа юм. Тэгээд хар даа. Одоо Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хуулиар тогтсоноос гадуур хязгаарлах хариуцлага ноогдуулах болохгүй гэж байгаа юм. Угаасаа энийг шийдчихсэн шүү дээ. Зөрчлийн тухай хууль .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Тэгээд Байнгын хороо гаргаж байгаа юмыг бол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.5-аар ийм юм гаргаж болохгүй гэдгээ шийдсэн учраас Байнгын хороо, Улсын Их Хурал ч гэсэн өөрсдөө энэ дээр ажиллах ёстой гэдэг дээр санал нэг байна.

Захиргааны ерөнхий хууль дээр 5.3, 3.14 дээр яг шүүх, прокуророос өөрсдийнхөө хуульд заасан эрх мэдэл болох буюу гэмт хэрэг эрх зүйн маргаан хянан шийдвэрлэх онцгой бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрээс бусад захиргааны чиг үүрэг шийдвэртэй нь холбогдуулан уг байгууллагыг захиргааны байгууллага гэж тооцно. Энэтэй холбоотой гаргаж байгаа хэм хэмжээг бол бид нар шинж чанараар нь захиргааны хэм хэмжээний акт болох уу, үгүй юу гэдгийг бас шинэчлэх ийм юм бол байгаа. Тэгээд харин сая уг сууриар нь бас хараач гэж байгаа бид нарын тайлбар бол энэ өргөн барьсан төсөлд бол хөндөгдөөгүй байгаа учраас энийг ингээд бүр дэлгэрүүлж бид нар ажиллах ямар ч боломж байхгүй. Цаана цаанаа энийгээ бол дахиад харж үзээд, ер нь нэг цэгцлэх ажил хийгдэх ёстой гэдэг дээр бол санал байгаа.

Д.Цогтбаатар: Ингээд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн 5, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан 4, Сайнзориг гишүүн 8 зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байгаа. Тэгэхээр зарчмын зөрүүтэй саналын хувьд бол би мэдэж өгч болохгүй болчихсон байж байна шүү дээ. Одоо энэ хурал дээр бол би яагаад ч шийдэж чадахгүй юм байхгүй юу.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.20-д төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна гэж заасан байгаа.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.9-д заасны дагуу 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн Байнгын хорооны 3 дугаар тогтоолоор уг хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан.

Иймд төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахдаа Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналыг уншиж танилцуулаад явъя.

Ингээд төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалттай холбогдуулан гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалангийн саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан. Энэ томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтаа түр хүлээж байя. Тайлбар хэн хийх вэ.

Хасаж байгаа заалт нь 12.4.Энэ хуулийн 12.1.3, 12.1.6-д заасан аргачлал нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д

заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй гэснийг хассан байна.

Номинчимэг гишүүн эхлээд тайлбараа хийе.

О.Номинчимэг: Энэ санал бол нөгөө чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 буюу нэн яаралтай орж ирж байгаа хууль тогтоомжид тавигдах шаардлага байгаа. Тэгээд энэ дээр та бүхэн бас хуулиа харах юм бол ер нь энэ нэн яаралтайгаар орж ирж байгаа хуульд, ер нь хууль тогтоомжид 4 төрлийн үнэлгээ аргачлалаар нөгөө баримт бичиг бүрдүүлж орж ирэх ёстой байдаг.

Нэн яаралтайгаар орж ирж байгаа хууль тогтоомжид бол хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалаас бусдыг нь бол хийдэг байя. Би өмнө нь бол дөрвүүлэнг нь хийдэггүй байсныг нь энэ 2 бол нэлээн бас нэн яаралтай орж ирж байгаа зүйл хийхэд хугацаа ордог учраас үүнээс бусад хууль тогтоомж боловсруулах мэдээж урьдчилан тандан судлах аргачлал болон холбогдон гарах зардлын тооцоо хийхийг бол заавал нэн яаралтайгаар орж ирж байгаа хууль тогтоомжийн хуулийн шаардлага болгож шинээр оруулж ирж байгаа гэсэн үг. Тэгэхээр өмнө нь ямар ч шаардлага тавьдаггүй байсныг ядаж 2 шаардлагыг нь бол тавьдаг болъё гэсэн энэ хуулийн төсөлд бол байгаа. Жаргалан гишүүний санал бол 4 зүгээр энгийн хууль тогтоомжид энгийн байдлаар өргөн баригдах хууль тогтоомжид тавих бүх аргачлал, шаардлага баримт бичгийг хийдэг. Нэн яаралтай хууль тогтоомж дээр ч гэсэн хийдэг болъё гэсэн санал байна. Тэгэхээр энэ дээр бид нар Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай бас ярилцсан. Ер нь мэдээж нэн яаралтай хууль тогтоомжийг бид нар ул суурьтай хийхийг зорино. Гэхдээ нөхцөл байдлаас үүдээд ялангуяа энэ үр дагаварт үнэлгээ хийх ажил бол нэлээн хугацаа ордог учраас энийг хассан нь дээр. Үүнээс болоод хугацаа авдаг, тэгээд нөгөө нэн яаралтайгаар хийх тэр нөхцөл байдал нь арилах ийм үр нөлөө гарч магадгүй гэж бодож байгаа учраас та бүхэн маань илүү хуулийн төсөл дээр орж ирж байгаа бас саналаа дэмжээсэй гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Энэ судалгаануудаас гэдэг юм уу тандан болоод хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнээс чөлөөлөгдөх харилцааг 12.1 дээр тодорхой заачихсан юм. Энэ заалт ер нь угтаа хэрэггүй байгаа юм. Одоо энэ төслийг нь ч гэсэн хэлэлцүүлж байгаа юм нь зөвхөн тандан судалгааг л хийе гэж байгаа байхгүй юу. Тандан болоод үр нөлөө. Тэгэхээр хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээд ороод ирж болно. Сая нэн яаралтайгаар өргөн хэлэлцүүлсэн Биржийн тухай хууль байгаа байхгүй юу. Биржийн тухай хуулийн энэ зохицуулалт болохгүй байна гээд хэрэгжилтийг нь үнэлээд, энийг нь засахгүй бол болохгүй юм байна гээд яаралтай хэлэлцүүлэх гээд ороод ирж байхад бид нар хааж байна гэсэн үг. Зөвхөн тандан хийнэ. Тандан гэдэг чинь огтоороо хууль дээр байхгүй юмыг шинээр тандаж гаргаж ирээд зохицуулах уу, үгүй юу гэж ярьдаг болохоос биш энэ асуудал. Тэгэхээр энэ ерөөсөө төсөл нь ч болохгүй байна. Жаргалан гишүүний гаргаж байгаа санал ч бас болохгүй байна. Тэгэхээр энийг бараг эцсийн хэлэлцүүлэг дээр яривал яадаг юм бэ. Энэ одоо хар даа. Төрийн үйл ажиллагааг гацаах гээд байна шүү. Энэ биржийн хуулийг жишээ нь би ганцхан жишээг аваад ярьж байгаа юм. Энэ зохицуулалт нь болохгүй байна, хэрэгжилт нь болохгүй байна гээд дүгнэхдээ байхад бид нар үүгээр яаралтай горимоор авч хэлэлцэж болохгүй заалтыг оруулчхаж байгаа

байхгүй юу. Энэ улс эх орны чинь эдийн засагт юу ч тохиолдож болно. Ийм байж болох юм уу. Би харин хэлээд байгаа шүү дээ. Янз бүрийн фэйсбүүкээр хүн рүү томорч болно. Гоё юм хийх гэж байгаа юм шиг пи ар хийж болно ажлын хэсгийн гишүүд ээ. Тэгэхдээ та нар ерөөсөө яг энэ үр дагавруудыг нь ерөөсөө тооцохгүй байгаа шүү. Хурлын даргын зөвлөх гэхээрээ л томроод байдаг юм байхгүй шүү. Би энийг бүр хатуу хэлчихье.

Д.Цогтбаатар: Энэ дээр байна шүү дээ. Отгончимэг зөвлөх. Үгүй ээ үгүй. Гэхдээ энэ дээр тайлбараа ер нь ямар утга агуулгатай санал оруулж ирсэн юм. Энд би тайлбар сонсмоор байна шүү дээ бас. Яагаад гэвэл ажлын хэсэг ажиллачихсан. Би бас өөрөө энэ чинь гүйцэд энэ ажлын хэсгийн ярьсан юмнуудыг нь танилцаагүй байхад би гишүүний хувьд сонсмоор байна шүү дээ. Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Тэгэхээр нэн яаралтай оруулж ирж байгаа хууль дээр зөвхөн нөгөө тандан судалгаа, хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг бол заавал хийж байа л гэдэг хуулийн төслийн үзэл санаа байгаа юм. Тэгээд яг Сайнзориг гишүүний хэлж байгаагаар тандан судалгааг бол байхгүй байгаа харилцаан дээр хийх гэж байгаа хууль дээр байдаг. Тэгэхдээ бид нар бас өмнөх онуудад жишээ нь ковидын хууль гээд байхгүй байгаа харилцаа шинээр яг нэн яаралтайгаар энэ үүссэн нөхцөлтэйгөөр ингээд хууль гаргаж байсан. Зөндөө ч шүүмжлэл гаргаж байсан. Тэгэхээр яг ийм нөхцөлд мэдээж байхгүй байгаа харилцааг зохицуулахдаа ядаж тандан судалгаагаа хийгээд ковидын хууль шиг ч байдаг юм уу, амьдрал баян гэж ярьдаг. Хэзээ цар тахал болох вэ. Хэзээ янз бүрийн ийм нэн яаралтайгаар улс орныхоо, нийгмийнхээ яг хүний эрхийнхээ асуудлыг шийдэх ийм хууль тогтоомжийг гаргаж ирэх вэ гээд тэгэхээр энэ дээр бол тандан судалгаа хийчихэд энэ бол тийм аймаар бас хүнд хэцүү олон өдөр шаарддаг судалгаа биш гэдгийг бол манай мэргэжлийн ажлын хэсгийнхэн бол хэлж байгаа юм.

Холбогдох зардлын тооцоог бол яалт ч үгүй хийх ёстой. Бид нар нөгөө хууль тогтоомжийн бодлогын шийдвэр гарч байгаа бол үр нөлөө эд нараас гадна эдийн засгийн хувьд ямар зардал гараад, бид нар юуг хийгээд, юуг бид нар олж авах гээд байна гэдгийг тоон дээр бас харах хэрэгтэй байдаг. Энийг ч гэсэн нэн яаралтай дээрээ бас харж байа гэдэг юм гарч байгаа юм. Нөгөө талаараа төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээ, тэгээд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ гэдэг бол зарим тохиолдолд ялангуяа хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ гэдэг бол нэлээн хугацаа шаардагддаг эрдэмтдэд бас ордог. Олон хоног шаарддаг болохоор нөгөө бид нарыг нэн яаралтайгаар оруулах гэж байгаа энэ зорилгод бас хаалт болох вий гэдэг утгаар л энэ 2-ыг юу ч гэсэн хийе гэдгээр хуулийн төсөлд өргөн барьсан хууль боловсруулагчдын үзэл баримтлалд бол байгаа юм байна лээ. Тэгэхээр яг аль аль талаа бодсон ч гэсэн нөхцөл байдалд хамгийн багадаа бид нар нэн яаралтайгаар орж ирж байгаа хуулийн төсөлд тэгвэл ямар мэдээллийг хууль тогтоочоод заавал авах ёстой вэ гэдэг л үндэслэл дээр энэ орж ирж байгаа.

Жаргалан гишүүний саналаар энэ бүгдийг заавал хийдэг болгочих юм бол нэн яаралтай ер нь байх шаардлага байх юм уу, үгүй юм уу. Судалгааны явц нь адилхан болохоор түргэн шуурхай бас маневрлах тэр боломж нь бол хязгаарлагдах юм гэж харж байгаа.

Д.Цогтбаатар: Тайлбараа өг өг.

П.Сайнзориг: Тандан болон хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнээс чөлөөлөгддөг хуулиудыг 12.1 дээр заачихсан байхгүй юу. Яаралтай горимоор хэлэлцэнэ гэдэг чинь энэнээс бас зугтааж байгаа хэрэг биш юм. Улсын Их Хурлын процесс яаралтай яваасай гэсэн болохоос биш боловсруулалт дээр ерөөсөө яараарай гэж юм яриагүй байхгүй юу. Энэ хуулиуд дээр энэ энэ харилцаанууд дээр чинь тандан хийхгүй байж болно. Энэ энэ дээр хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхгүй байж болно гээд заачихсан юм. Энэ дээр юу байгаа нь мэдэгдэхгүй зүгээр ийм яаралтай горимын хуулиудыг ингэж гаргана гэж бас болохгүй байгаа юм.

2 дугаарт сая биржийн хуулийг ярьж байна шүү дээ Номин. Энэ дээрээ л тайлбар өгөх ёстой. Хэрэгжиж байгаа хууль дээр тандан хийнэ гэж байхгүй шүү дээ. Хэрэгжиж байгаа хууль дээр хэрэгжилтийн үр дагавар. Тэгэхээр энэ чинь цаашдаа ингээд бүх юмыг зохиох гээд байна. Тэгэхээр Жаргалан гишүүний хэлж байгаа санал бас зөв байгаа байхгүй юу.

Д.Цогтбаатар: Хэдүүлээ энэ дээр санал хураалтаа явуулъя. Ажлын хэсгийн ярьж байгаа байр суурь нь зөв шүү энэ дээр. Санал хураалтдаа бэлдье.

Би аль болох хэлэлцүүлгийг нээлттэй явуулж байгаа шүү. Одоо гэхдээ бас дэгээ хэдүүлээ бариад явъя. Санал хураалтдаа бэлдье. Гишүүд хуруугаа бүртгүүлээрэй. Тэгвэл Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ 12.2.17 дээр яг өмнө нь бол энэ 4 төрлийн судалгаа чинь Дэгийн тухай хуулийн 21.1 буюу бид нарын шинэ хуулиар бол 33.1-д байсан яаралтайгаар, нэн яаралтайгаар өргөн баригдах хуулийн төсөлд энэ 4 чинь хамаарахгүй гэдэг юмыг нь энэ хуулийн төсөлд бол хасаад ороод ирчихсэн байхгүй юу. Тэгэхээр Жаргалан гишүүний хэрвээ санал дэмжигдэх юм бол вакум үүсчих гээд байна. Яг нэн яаралтайгаар өргөн баригдах хуулийн төсөлд энэ 4 чинь бүгдээрээ ордог болчихно шүү дээ. Яагаад гэвэл 12.2.17-г нь юмыг бол хасчихсан. Энэ өөрөө Хууль тогтоомжийн Улсын Их Хурлын дэгийн хуультайгаа ч гэсэн зөрчилдчихсэн одоо зүйл заалт байгаа учраа хуулийн төсөл бол анх орж ирэхдээ энийгээ хасаад ороод ирчихсэн байгаа шүү л гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: Зөв зөв. Би энэ ажлын хэсгийн тайлбарыг бол ойлгож байна. Санал хураалтдаа бэлдье. Ингээд сая Жаргалан гишүүний саналыг уншиж танилцуулсан шүү дээ. Тэгээд энэ танилцуулсан томьёоллоор Жаргалан гишүүний саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Манайхан бэлдсэн үү. Санал хураалт явуул явуулъя. Дэмжигдсэнгүй. Дэмжсэн 29,4 хувь, татгалзсан 70,6 хувь. Энэ санал дэмжигдсэнгүй.

Ингээд цаашаа явъя. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.3.3 дахь заалтын “жендерийн мэдрэмжтэй” гэснийг болон 17.3.2 дахь заалтыг тус тус хасаж, 17.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.3.4.хязгаарлалт нь зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх” Ажлын хэсгийн санал ийм байна. Үүнтэй

холбогдуулаад санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор. Одоо энэ дээр дэгээрээ ямар нэгэн үг байхгүй. Сайнзориг гишүүн байр сууриа хэлье.

П.Сайнзориг: Уг нь энэ асуудал ийм байгаа юм. Тандан судалгааны аргачлал бол төслийн үр нөлөөний аргачлал дээр буюу Засгийн газрын баталж байгаа аргачлал дээр л энийг оруулчихад болох юм байгаа юм. Одоо жишээ нь хязгаарлалт тогтоосон, зорилгод нийцсэн буюу бодит нөхцөлд тохирсон, боломжит, хамгийн бага түвшинд. Өргөн барих төсөл дээр ингэж субъектив байдлаар ханддаг Тамгын газрын ажилтнуудын субъектив эрхээр шийддэг ийм зүйл өгч болохгүй. Харин өргөн барьсны дараа ажлын хэсгээс байдаг юм уу, Байнгын хорооноос, чуулган дээрээс чиглэл өгсний дагуу энэ чиглэлд нь зорилгодоо нийцэж үү, бодит нөхцөлд тохирсон байна уу, хамгийн боломжит бага байдлаар хязгаарласан байна уу гэдэг дээр дүгнэлт гаргаад ир гэвэл энэ өргөн баригдсаны дараа буюу хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа шийддэг асуудал байхгүй юу. Энэ чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр байж болно. Энэ өргөн барих хэсэг дээр ингэж Улсын Их Хурлын Тамгын газар дүгнэлт гаргаад, хууль буцаадаг, санаачлагчид нь буцаадаг энийг улам лавшруулаад хэрүүл болгох гэж байгаа ийм зүйл байж болохгүй. Юу хийгээд байна даа. Одоо хар даа. Үгүй ээ дүгнэлт гаргана. Тэгээд энэ чинь хачин юм болоод сүүлдээ энэ чинь мэдэхгүй. Энэ би ерөөсөө бүр ойлгохоо байж байна. Би энийг огтоосоо агуулгыг нь эсэргүүцээгүй. Энэ өргөн барьсан төсөл дээр харин дэгийн хуулиар юм уу, ажлын хэсгээс чиглэл өгөөд Тамгын газрын экспертийн албуудаар гаргуулж болох асуудал байхгүй юу. Өргөн барьж байхад ийм юм шийдүүлж болохгүй. Өргөн барих гэдэг бол Үндсэн хуулиар олгогдсон хууль санаачлагчийн бүрэн эрхийн асуудал шүү. Ийм сонин сонин юмнууд хийгээд яваад байгаа. Энэ одоо мэдэхгүй. Одоо больчихооч гэдэг зүйлийг л хэлмээр байна. Энэ дараагийн процесс байхгүй юу. Өргөн баригдсаны дараа энийг хийлгэж болно. Би энийг дэмжиж байна. Тамгын газар хийж болно. Дэмжиж байна.

Д.Цогтбаатар: Одоохон. Сайнзориг гишүүн ээ би таны ярьж байгааг ойлгож байна. Гэхдээ та жишээлбэл хийсэн тэр дүгнэлт нь ёстой юу гарах бол доо. Бид нар одоо ийм субъектив юм ярьж болохгүй шүү дээ. Тэр чинь гардаг журмаараа л гараад. Сайн ч гарч болно, муу ч гарч болно. Төрийн эрх бүхий байгууллагууд чинь дүгнэлтээ гаргаад л явдаг юм шүү дээ. Одоогоос бид нар тэрийг энэ муу л байж таарна гэж дүгнээд бусдыг голоод суугаад байж болмооргүй байна шүү дээ. Номинчимэг гишүүн энэ дээр ажлын хэсэг тайлбараа өгдөө.

О.Номинчимэг: Яг энэ 17.3 гэсэн заалтыг харах юм бол хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах хэм хэмжээтэй хууль тогтоомж орж ирэх юм бол энэ 17.2.4-д буюу бид нарын ярьсан хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлэх баримт бичиг оруулж ирж байгаа. Одоо хуулиа бид нар хүний эрхийн ингээд мэдрэмжтэй болгоод өгье л гэж байгаа. Эндээ л энэ шалгуур үзүүлэлтээр энэ үнэлгээ дүгнэлтээ хийгээд, өөрөө хуульд санаачлагч нь ч гэсэн оруулаад ирээч ээ л гэдэг ийм шаардлага байгаа юм. Тэгэхээр бид нар энийг бас аргачлалаа 2, 3 газар янз бүрийн аргачлал гарчихсан байгаа. Энийгээ бид нар яаж системдээ зөв ашиглах вэ. Энийгээ хэн хэнээ бас зөв ойлголттой болохгүй бол яг одоо Сайнаа гишүүний болгоомжилж байгаа юмыг бол ойлгож байгаа. Хүний эрх гэдэг юмыг бид нарын ойлголт зөрүүтэй байдлаас болоод энэ шалтгаанаар буцаах ч байдаг юм уу янз бүрийн асуудал эрсдэл гарахгүйн тулд бид цаашид аргачлалаа бас нэгтгэж боловсронгуй болох хэрэгтэй юм байна лээ. Дээр нь энэ дээр үнэлэлт, дүгнэлт өгөх гэж байгаа Хүний эрхийн комисс дээр нь Тамгын газрын

үнэлгээнийхэн энийг судлаад байх, эд нар дээрээ чадавхжуулах ажлаа бол яалт ч үгүй давхар сайн хийх ёстой. Энийг бас протоколд ч гэсэн энийгээ сайн хийхгүй бол хааяа миний хувьд ч гэсэн хуулийн төсөл боловсруулаад хүний эрхийн комиссоос санал авахад бол гайхмаар гайхмаар санал бас орж ирдэг юм. Тэгэхээр энийг хүний эрхийн энэ нөлөөллийн үнэлгээг хийх аргачлалыг болон чадавхаа бас давхар маш сайн сайжруулах ёстой шүү. Гэхдээ бид нар 1 алхам урагшлахын тулд хууль тогтоомжийнхоо өргөн барих энэ материал дээрээ энийгээ заавал бас дүн шинжилгээ хийж оруулдаг байя л гэсэн шаардлага байгаа шүү гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгчихье. Уг нь дэг байхгүй. Гэхдээ би танд өгчихье.

Н.Алтанхуяг: Хөөш та нар минь энэ их чухал хууль шүү. Та нар, манай энэ хуулийн чиглэлийн хүмүүс сайн үзээрэй. Би бол яг Сайнзориг гишүүний хэлээд байгаа тэр хуулийн төсөл өргөн барих үед баахан юм нэхдэг, тэр нь илүү субъектив шинжтэй байх бол их хортой гэдгийг би амьдралын 1 кэйс дээр хэлэх гэж байгаа юм. Би өнгөрсөн 4 жилд ганц тогтоолын төсөл өргөн барьсан юм. Нөгөө нэг овоолго дээр болсон юм 34/33/33 гээд нэг юм хийсэн чинь одоо манай Тамгын газар их субъектив байдлаар дүгнэлт хийж байгаа юм. Бүр дүгнэх дүгнэхдээ ямар айхтар дүгнэлт хийж байна вэ гэхээр энэ Алтанхуягийн өргөн барьсан энэ Их Хурлын тогтоолын төсөл Үндсэн хууль зөрчиж байна гэж солиорсон байхгүй юу. Бүр тэгээд бичиж орж ирээд, Байнгын хороо дээр түүнийгээ уншаад. Тэгээд Үндсэн хууль зөрчсөн эсэхийг чинь Агар-Эрдэнэ чи шийдэхгүй байхгүй юу. Нөгөө этгээд нь энд сууж байна л даа. Тийм би зөндөө хэрэлдсэн байхгүй юу.

Үгүй ээ, би хууль, тогтоолын төсөл өргөн барьж байгаа. Энийг чи шийдэхгүй. Чи энийг шийдэхгүй. Үндсэн хуулийн цэц гэж байгууллагатай байхгүй юу. Тэгээд яагаад чи ингээд байгаа юм. Миний хүү тэгвэл анхнаасаа ярья. Эрдэнэтийн 34 хувийг Цагаан гэдэг нөхөр анх гэрээ байгуулж авчхаад, Эрдэнэтэд 34 хувиа өгнө гэхдээ явцын дунд хулгайгаар 0 болгочихсон. Энэ хүн юм хулгайлаад авчихсан байхад нь чи миний тогтоолын төслийг хувийн өмчид халдлаа, Үндсэн хууль зөрчлөө гэж байгаа юм. Би зүгээр ганцхан кэйс ярьж байгаа Цогтбаатар дарга аа.

Тэгээд би бас та нарт ямар санал хэлэх гээд байна вэ гэхээр Тамгын газрын хүмүүсийн аманд аваачиж хууль санаачлагчдын эрхийг битгий өгөөч. Тэгээд ийм юман дээрээ та нар анхаараад өгөөч.

2-т яг ингээд цагт шахагдаад хэдүүлээ маргаж байхаар энийгээ яарах юм байхгүйгээр дахиад цаг гаргаад их олон кэйсүүд ярьж байгаад, тэгээд ингээд зөв шийдмээр л байна. Миний бодол бол. Би та нарт 1 кэйс ярилаа шүү. Нэлээн олон кэйс Их Хуралд өргөн барьсны дараа явдаг кэйсүүд би бас их яримаар байгаа байхгүй юу. Дараачийн удаа Их Хурлын дарга аваачаад 2 шатын хэлэлцүүлэг дамжсан юмыг ширээн доогуураа хийгээд тэгээд бүхэл бүтэн тэр Прокурорын дэргэдэх мөрдөнгийн тухай хуулийг дараачийн парламент руу шидээд ерөөсөө хэлэлцэхгүй хаячхаж байгаа юм. Ийм дарга нар гэдэг хулгайч нарын дур зоргын юмыг бол хаамаар байна. Одоо дээр нь Тамгын газар чинь өөрөө дарга нар болчихсон шүү. Ийм хачин юм руу аваачаад хийгээд байвал буруу. Би энийг дэлгэрэнгүй уншаагүй. Концепцын хувьд бол Сайнзориг гишүүний хэлж байгаа концепцыг та нар маань б/и маргаж байгаа юм биш шүү/ жаахан нягтлаад өг л дөө. Тэгээд хэдүүлээ зөв юм хийе.

Ер нь энэ та нарын анхны гаргаж ирсэн концепцыг би дэмжиж байгаа. Энхбаяр гишүүн ч байнга ярьдаг. Хуулиас гадуур дур зоргоороо дүрэм журам гаргаад бид нар хамаг эрх мэдлээ дарга нарт өгч байна. Дарга нар нь тэгээд 1 ийм баахан журам..../минут дуусав/

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүн ажлын хэсгийн даргын хувьд яг тайлбар өгөх боломжийг нь олгоё. Гэхдээ энэ дээр Алтанхуяг гишүүн ээ ийм юм шүү. Саяын таны ярьж байгаа юм дээр би ч зөндөө хууль гаргаад, энэ хүнд суртлын механизмууд дундуур ороод, жишээлбэл, миний маш зөв тогтоолын төсөл батлагдаагүй шүү дээ. Барьж байгаад л зогсоогоод явуулж байгаа байхгүй юу. Одоо тэр тогтоолын төслийн асуудлаар чинь тэрний заалт болгоноор залуучууд гаргаж ирж яриад од болж байна шүү дээ. Би тэрийг 2 жил яриад яваагүй байхгүй юу. Гэхдээ тийм юмнууд тэртээ тэргүй төр нөгөө шалгууртай түвшин түвшиндээ л ахиад л хүмүүс субъектив үзнэ шүү дээ. Тэгэхээр субъектив үзлүүдийг яаж бид нар нитралжуулах вэ гэхээр оролцогчдын тоог л нэмэхээс өөр үггүй. Тэрийг цөөлчих л юм бол яг таны хэлж байгаа эрсдэлүүд гарах байхгүй юу. Тэр үзэл санаа л энд орсон байгаа юм. Тэгээд Номинчимэг гишүүн тайлбараа өгөөч.

О.Номинчимэг: Ойлгож байна. Гишүүдийн хэлж байгааг. Гэхдээ буруу ойлголт явчихлаа. Энэ шаардлага байна шүү дээ одоо бид нарын санал хураах гээд байгаа 17.3 дээр байгаа энэ шаардлага Тамгын газар орж ирэхээрээ энийг харж дүгнээч гэдэг шаардлага биш байхгүй юу. Энэ хууль тогтоогч, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг та тогтоолын төслөө юм уу, хууль санаачлахдаа хэрвээ хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах гэж байгаа хууль санаачлах гэж байгаа бол ийм шалгуураар энийгээ үнэлээд оруулж ирээч ээ. Таны өөрөө хийх ажил байхгүй юу. Тэгэхээр энэ дээр объективний ч байдаг юм уу субъективний байдлаар Тамгын газар байдаг юм уу, үнэлгээний газрынхан энийг харж байгаад таны юмыг зохиох гээд байгаа юм бол биш юм. Харин ч хүний эрхийн энэ хязгаарлаж байгаа асуудал дээр хууль тогтоогч өөрөө энэ чинь яаж нөлөөлөх юм бэ гэдгийг дүн шинжилгээ хийж оруулж ирж байя. Нөгөө хүний эрхийн мэдрэмжтэй энийгээ сайн хардаг байя гэдэг хууль тогтоогч боловсруулж байгаа этгээдэд тавьж байгаа шаардлага гэдгийг нь тодруулж хэлэхгүй бол одоо ингээд буруу ойлголт яваад, буруу тийшээгээ мушгиад байна. Тэгээд Алтанхуяг гишүүн хэрэгтэй бол та уншиж танилцаагүй гэж байна. Энэ шигтгэсэн хуулиуд дээр ер нь орж ирсэн хууль маань юу байгаа юм гэдэг уялдаатай харахгүй бол 1, 1 заалтаар нь сугалаад явах юм бол буруу ойлгогдоод явчих магадлал байна шүү гэдгийг бас хэлье.

Д.Цогтбаатар: Түрүүн ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулсан. Энэ өөрөө зөв санал явж байгаа юм. Тэгэхлээр би дахиж уншиж танилцуулах хэрэггүй шүү дээ. Түрүүн уншиж танилцуулснаар ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Унаж байна. Энэ санал тэгвэл унаж байна. Үгүй ээ, үгүй. Тэгээд ажлын хэсэг би бол бас өөрийнхөө зүгээс яриад л явж байна. Тэгэхдээ Алтанхуяг гишүүн ээ, сая бол энэ чинь уншсантай холбогдуулаад би бол дэмжиж санал өгсөн. Тэгвэл би өөрөө горимын санал гаргачих уу. Ингэе би бол сая эсрэг санал биш, дэмжсэн санал өгсөн. Энд эсрэг гарчихсан байна. Тэгэхээр саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Манай Байнгын хороо би бол энийг чинь бүр хойшлуулж байгаад оруулж ирж байна шүү дээ. Зөндөө хойшлууллаа. Одоо би гишүүн болгон дээр ажлын хэсгээ аваачиж ажиллуулах юм уу.

Сайнзориг гишүүн ээ, таны саналыг ерөөсөө хураахгүй гээгүй. Дэгээрээ явахаар ажлын хэсгээс орж ирснийг эхэлж хураагаад, тэр нь унавал таны саналаар хураагдана шүү дээ. Энэ чинь дэг нь ийм байхгүй юу. Би тэрийг ерөөсөө зохиогоогүй байна. Тэгээд Жаргалан гишүүний саналаар одоо хураая. Угаасаа дэгээрээ ийм байгаа. Тэгэхээр юу ч гэсэн явуулах гээд л үзье. Жаргалан гишүүний саналыг би уншиж танилцуулъя.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3 дахь хэсгийн 17.3.2 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан. Санал хураалт. Түрүүний санал унасан. Одоо тэгээд Сайнзориг гишүүний саналаар нь би санал хураалгая. Би бол одоо энэ саналыг бол дэмжихгүй. Тэгээд наадах чинь анх оруулж ирсэн юугаараа л өөрөө сэргээд босоод явчихсан. Манайхан санал хураалтдаа бэлдээрэй. Яах вэ энэ чинь тэгэхээр анх оруулж ирсэн чинь босчихож байгаа байхгүй юу даа. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Саяын 17.3.4-д байгаа хязгаарлалт нь зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх гэдэг энэ зохицуулалт юм уу, хэмжигдэхүүн орж ирж байгаа юм. Энэ нь юу вэ гэхээр ер нь бол хүний эрхийг хязгаарлахтай холбоотой хуулийн төслүүд дандаа Засгийн газраас орж ирнэ. Улсын Их Хурлын гишүүд бол нэг их санаачлахгүй. Засгийн газраас орж ирэхэд Улсын Их Хурал дээр Улсын Их Хурлын 126 гишүүн энэ хууль чинь зорилгодоо нийцсэн хязгаарлалтыг хэрэглэсэн юм уу, үгүй юм уу гэдэг үгийг асууж, хэмжих боломжтой болно гэсэн үг. Бодит нөхцөлд тохирсон уу гээд кэйсүүдээ ярих боломжтой болно гэсэн үг. Тэгээд боломжийн хамгийн бага түвшинд байна уу гэж иргэний талд зогсох, ярих, иргэдийнхээ байр суурийг Улсын Их Хурал дээр хамгаалах боломжтой болно гэсэн үг байхгүй юу. Энэ хэмжигдэхүүн хууль тогтоогч нарт Засгийн газраас өргөн барьсан хуулийг метрлэж, хэмжиж, эсвэл литрлэж, жигнэж болох тэр үзүүрийг бий болгож өгч байгаа юм. Энэ өөрөө хамгийн гол нь амин сүнс нь тэр байхгүй юу. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд хувийн байр сууриараа, хувийн зохиолоороо өглөө сэргэж ирсэн ааш аягаараа хуулийг шүүмжлэх биш, 1 хэмжүүртэйгээр ярьж, нэгдсэн ойлголтод хүрч, энэ хууль яах аргагүй иргэнд зориулсан байна, иргэний эрхийг боломжит тооцож байгаа хүрээндээ хязгаарлах байна. Хязгаарлаж чадахгүй байна гэдэг энэ яриаг л үр дүнтэй ухаалаг болгоход зориулж байгаа юм.

Д.Цогтбаатар: Тэгээд Алтанхуяг гишүүн ээ, та түрүүн бас хууль тогтоогчийн бүрэн эрхэд халдаж болохгүй гээд байгаа ч угаасаа энэ Хууль тогтоомжийн тухай хууль байгаа шүү дээ тэр чинь таныг хуулиа оруулж ирэхдээ ямар шаардлага хангах вэ гэдэг таны эрхэд тодорхой хэмжээнд ийм чиглэлээр явна шүү гээд түүнээс хязгааргүй эрх байгаа гэсэн үг биш. Ялангуяа хүний эрхтэй холбоотой асуудал дээр шалгуур давж байж л орж ирнэ шүү дээ. Та бид нар хуулиа барихад

Баасанжаргал гишүүн ээ, одоо больцгоо та нар. Байнгын хорооны хурал ийм байдлаар явахгүй. Алтанхуяг гишүүн ээ, би та бүгдээс нэг юм хүсмээр байна. Ажлын хэсгийн даргад үүрэг өгье. Би өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд өнөөдрийн энэ хуралдааныг зогсоолоо.

Ингэж явна гэдэг бол цаашдаа хуулиуд бол явахааргүй болж байна. Тэгэхдээ одоо яая гэх вэ хэдүүлээ зүтгэнэ. Алтанхуяг гишүүн дээр орёе. Энд эргэлзэж байгаа гишүүд дээр ороод яг энэ асуудлуудаа яриад л явахаас. Ингэж

хөдөлмөрлөж байж, 10 дахин илүү хөдөлмөрлөж байж л хууль гарах юм байна. Шинэ нөхцөл байдалдаа хэдүүлээ сэрцгээж, Монгол Улсын парламентын үйл ажиллагааны шинэ нөхцөл байдал ямар болсныг өнөөдөр бүгдээрээ амьдрал дээр харж байна гэсэн үг.

Манай Байнгын хороо бол ажлаа уг нь байнга тасалдахгүй явуулж ирсэн. Энэ соёлоо ядаад Байнгын хороо аваад үлдэх юм сан гэж би хүсэж байна. Яагаад гэвэл бид нар бусдын төлөө л хууль гаргах гээд л явж байгаа. Өнөөдөр байж байгаа хууль чинь бас гүйцэд ажиллахгүй байгаа болохлоор л энэ хуулийн төслийг боловсруулаад оруулж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр ажлын хэсэг бас нэмээд жоохон ажиллая. Харин энэ дээр би горимын санал гаргаж байна. Энэ хурлыг 7 хоногоор хойшлуулъя гэсэн горимын санал. Санал хураалт явуулъя. Горимын санал 52,9 хувиар дэмжигдлээ. Энэ горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулаад Байнгын хорооны хуралдааныг 7 хоногоор хойшлууллаа.

11.26 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ